НИЙСЛЭЛИЙН АГААР, ОРЧНЫ БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ ГАЗАР

# ТАНИЛЦУУЛГА

## МОНГОЛ УЛСЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ

2024 оны 12 дугээр сарын 16 Улаанбаатар хот

Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 2 арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна.

Хяналт шинжилгээний ажлыг **гүйцэтгэхдээ** Засгийн газрын 2020 оны 206, 2021 оны 374 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт шинжилгээ үнэлгээ хийв.

***Хяналт шинжилгээ хийсэн талаар:***

Нийт 8 арга хэмжээний хэрэгжилт нь 100%-2, арга хэмжээ тус ханган ажилласан бөгөөд ерөнхий үнэлгээгээр 100.%-ийн хэрэгжилттэй байна

ТАНИЛЦСАН:
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.МӨНХБААТАР

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА Г.АРИУНТУНГАЛАГ

ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН
ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ,
ХАМТЫН АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Г.ДӨЛГӨӨН

МОНГОЛ УЛСЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2024 оны 12 дугаар сарын 16-ний өдөр

Улаанбаатар хот

| № | ХБТББ*-т тусгагдсан зорилт/үйл ажиллагаа | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ** | Хэрэг-жих хугацаа | Үндсэн хэрэгжүү-лэх байгууллага | Эх үүсвэр | Нийт хөрөн-гийн хэмжээ (сая төгрөг) | Суурь түвшин | Зорилтот түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ эх үүсвэр) | | | Хэрэгжилтийн явц | Хэрэг-жил-тийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Төсөв (сая.төг) | Төсвийн гүйцэтгэл (сая.төг) | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
| ЗУРГАА. НОГООН ХӨГЖИЛ | | | | | | | | | | | | |
| 1 | 6.4. Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж, байгальд ээлтэй, нөөцийн хэмнэлттэй, үр ашигтай цэвэр технологи нэвтрүүлэн, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох үндэсний чадавхыг бүрдүүлнэ. | 6.4.4. Хүлэмжийн хийн ялгарлыг 12.3 хувиар бууруулна. | 2021 - 2025 | | | | | | | | Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд "Ногоон технологи-2024" үзэсгэлэнг 9 дүгээр сарын 18,19-ний өдрүүдэд Сүхбаатарын талбайд зохион байгуулсан. Тус өдөрлөгөөр байгальд ээлтэй, нөөцийн хэмнэлттэй, дэвшилтэт техник, технологи инновацын шийдлээ танилцуулж, нийт 80 аж ахуй нэгж байгууллагууд оролцож 2 өдрийн турш нийт 5000 гаруй иргэд олон нийтэд сурталчилж ажилласан болно. Уг ажлын хүрээнд 5 мэдээллийн сувгаар видео болон ярилцлага үйл явдлын мэдээ, сурвалжлаг зэрэг мэдээллийг нийт 10,000 гаруй иргэд олон нийтэд хүргэж ажилласан.<br>Мөн угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлье, зуухаа зөв галлах зааварчилгаа, байшин сууц хаагуураа | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | дулаанаа алддаг талаар, хямд аргаар хэрхэн гэрээ дулаалах зэрэг мэдээлэл багтаасан нийт 1200 гаруй брошюрыг иргэд олон нийтэд танилцуулж тараан хүргэсэн. Мөн хагас жилийн байдлаар 9 дүүргийн хэмжээнд 3 төсөл хөтөлбөр хэрэгжүүлж, гэр дулаалах заавар зөвлөмж бүхий видео болон пасторыг цахим хуудсаар дамжуулан 2.0 сая хүнд хүрч 40.000 хүн хариу үйлдэл үзүүлж, 14,300 хүн бусадтай хуваалцаж, 700 гаруй хүн сэтгэгдэл үлдээж иргэд олон нийтэд сурталчилж ажилласан болно.<br>Нийслэлийн Засаг даргын А/1025 захирамжийн хүрээнд үүрэн телефоны үндэсний оператор Юнител ХХК-ний ДДЭШ кабелийн телевизээр 3 удаагийн давтамжаар нийт зорилтод бүлгийн 15000 өрхөд Угаарын хийнээс урьдчилан сэргийлэх, зөв галлагаа, угаарын хийн мэдрэгчийг зөв ашиглах талаар зөвлөмж хүргүүлэн ажилласан болно. | |
| 2 | 9.2. Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангаж, нөхөн сэргээх, хариуцлагатай, хэмнэлттэй | 9.2.1. Улаанбаатар хотын агаарын бохирдлыг 80 хувь бууруулна. | 2021 - 2025 | | | | | | | | "Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр", Засгийн газрын 2018 оны 62 дугаар тогтоолын хүрээнд:<br>**Сайжруулсан шахмал түлшний тээвэрлэлт:**<br>Нийслэлийн Засаг даргын 2024 оны "Эрх шилжүүлэх тухай" А/118 дугаар | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэглээг бий болгоно. | | | | | | | | | | захирамжаар нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд сайжруулсан шахмал түлш тээвэрлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахыг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, гэрээ байгуулж ажиллахыг НАОБТГ-т тус тус даалгасан. Энэ ажлын хүрээнд нийслэлийн 7 дүүргийн хэмжээнд 2024-2025 онд сайжруулсан шахмал түлш тээвэрлэх 30 багц ажлыг www.tender.gov.mn-д зарлаж 29 тээврийн компанийг хуулийн хүрээнд сонгон шалгаруулж "Сайжруулсан шахмал түлш тээвэрлэх гэрээ"-г байгуулсан. 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрөөс 2025 оны 12 дугээр сарын 13-ны өдрийн байдлаар 29 тээврийн компани нь зүүн болон төвийн бүсийн үйлдвэрээс эцсийн борлуулалтын цэг, агуулахад нийт 605,493 тонн сайжруулсан шахмал түлшийг тасралтгүй тээвэрлэн ажиллаж байна. НАОБТГ нь сайжруулсан шахмал түлш тээвэрлэгч аж ахуйн нэгж байгууллагуудад тээвэрлэсэн түлшний тонн хэмжээ болон гүйцэтгэлийг хянан 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар 21,69 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгон ажилласан. | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | **Сайжруулсан шахмал түлш нөөцлөлт:** Нийслэлийн Засаг даргын 2024 оны "Эрх шилжүүлэх тухай" А/121 дүгээр захирамжаар 2024-2025 оны халаалтын улиралд гэр хорооллын айл өрхийн хэрэгцээнд зориулж 100 мянган тонн сайжруулсан шахмал түлшний нөөц бүрдүүлж ажиллахыг НАОБТГ-т үүрэг болгосон. Энэхүү үүргийн хүрээнд НАОБТГ-ын даргын тушаалаар агуулах түрээслэх, сонгон шалгаруулах ажлын хэсгийг байгуулан 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн зохион байгуулж, шаардлага хангаж түлш нөөцлөх боломжтой 40 агуулахыг сонгон шалгаруулсан. 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар сайжруулсан шахмал түлш нөөцлөх боломжтой шаардлага хангасан 40 иргэн, аж ахуйн нэгж байгууллагатай "Сайжруулсан шахмал түлш нөөцлөх, гурвалсан гэрээ"-г байгуулан "Таван толгой түлш" ХХК, сайжруулсан шахмал түлшний тээврийн компаниудтай хамтран 73,678 тонн сайжруулсан шахмал түлшний нөөц бүрдүүлэн ажиллаж байна. 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар 5,523 тэрбум | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | төгрөгийн санхүүжилт олгоод байна.<br>**Сайжруулсан шахмал түлш борлуулалт:** Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд 2024-2025 онд сайжруулсан шахмал түлш борлуулагч 670 борлуулалтын цэгийг нээн ажиллуулахаар төлөвлөснөөс 2024 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн байдлаар 582 цэг ажиллуулаад байна. Гэр хорооллын 203,683 айл өрхөд сайжруулсан шахмал түлшийг ханган нийлүүлж, борлуулалтын цэгийн өдөр тутмын түлшний татан авалт, борлуулалтад хяналт тавин ажиллаж байна. Борлуулалтын урамшуулалд нийт 6,0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгоод байна.<br>Агаарын чанарын суурин харуулуудын мэдээг 7 хоног, сараар боловсруулан гаргаж Ус, цаг уур орчны шинжилгээний газарт хүргүүлэн ажиллаж байна.<br>Улаанбаатар хотын агаарын чанарыг гэр хороолол, автозам, орон сууцны хороолол, үйлдвэрийн дүүрэг орчмын 19 цэгт агаар бохирдуулах бодис болох хүхэрлэг хий ($SO_2$), азотын давхар исэл ($NO_2$), $PM_{2.5}$, $PM_{10}$ тоосонцор, нүүрстөрөгчийн дутуу исэл (CO), озон ($O_3$) болон цаг уурын | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | үзүүлэлтүүдийг автомат багажаар тодорхойлоход 2024 оны хүйтний улирлын Улаанбаатар хотын агаар дахь бохирдуулах бодисын сарын дундаж агууламжийг өмнөх онуудын мөн үеийн сарын дундаж агууламжтай харьцуулахад $PM_{2.5}$ тоосонцор нь 3 мкг/$м^3$-ээр буюу 13%-иар , азотын давхар исэл ($NO_2$) нь 10 мкг/$м^3$-ээр буюу 27%-иар, бага, хүхэрлэг хий ($SO_2$) нь 10 мкг/$м^3$-ээр буюу 37%-иар тус тус их. Харин $PM_{10}$ тоосонцор нь 20 мкг/$м^3$-ээр буюу 19%-иар бага байна<br>Уурын болон усан халаалтын зуух эзэмшигч иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хүсэлтээр 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 11 дүгээр сарын 28-ний өдрийг хүртэлх хугацаанд нийт 35 зууханд хэмжилт хийж MNS 5043:2016, MNS 5919:2009, стандартад заасан үзүүлэлттэй харьцуулан хэмжилтийн дүнг боловсруулсан. Хэмжилтийн үр дүнг стандарттай харьцуулахад шаардлага хангаагүй 15 зуух байна. Хэмжилтийн орлого 8 сая төгрөгийг Нийслэлийн төсөвт төвлөрүүлэн ажилласан<br>Урьдчилан сэргийлэх болон төлөвлөгөөт бус удирдамжийн хүрээнд 15-100квт, 100 квт-аас дээш хүчин чадлын уурын болон усан халаалтын зуух | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | ашиглагч 611 объектод хяналт шалгалт хийснээс 61 иргэн, 550 аж ахуйн нэгж байв. | |
| | | | | | | | | | | | Дундаж хувь | 100 |

ТАНИЛЦСАН:
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.МӨНХБААТАР

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА Г.АРИУНТУНГАЛАГ

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
ТӨВӨЛЛӨГӨӨ, ТОГТООЛ
ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Р.ЖАМБАЛСҮРЭН

НИЙСЛЭЛИЙН АГААР, ОРЧНЫ БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ ГАЗАР

# ТАНИЛЦУУЛГА

## "НИЙСЛЭЛИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ" ДУНД ХУГАЦААНЫ ТӨЛӨВЛӨЛТИЙН БАРИМТ БИЧГИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ

2024 оны 12 дүгээр сарын 16 Улаанбаатар хот

Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичгийн шалгуур үзүүлэлтийн 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 8 арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна.

Хяналт шинжилгээний ажлыг **гүйцэтгэхдээ** Засгийн газрын 2020 оны 206, 2021 оны 374 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу хяналт шинжилгээ үнэлгээ хийв.

***Хяналт шинжилгээ хийсэн талаар:***

Нийт 8 арга хэмжээний хэрэгжилт нь 100%-3, 90%-3, 80%-1, 70%-1 арга хэмжээ тус тус ханган ажилласан бөгөөд ерөнхий үнэлгээгээр 90%-ийн хэрэгжилттэй байна

6.2.2 "Агаар бохирдуулагч эх үүсвэрүүдийг судалж, шинжлэх иж бүрэн лаборатори" арга хэмжээний үйл ажиллагаанд дан ганц манай байгууллагаас шалтгаалах бус бусад дээд шатны байгууллагатай хамтран шийдвэрлэх буюу хэрэгжилтийг хангахад шаардагдах төсөв шийдэгдээгүйн улмаас удаашралтай байгаа тул нэгж, газрын удирдлагууд анхаарах, цаашид эрчимжүүлэх санал хүсэлтийг холбогдох газруудад яаралтай хүргүүлэн ажиллах шаардлагатай байна.

ТАНИЛЦСАН:
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.МӨНХБААТАР

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА Г.АРИУНТУНГАЛАГ

ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН
ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ,
ХАМТЫН АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Г.ДӨЛГӨӨН

“НИЙСЛЭЛИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ” ДУНД ХУГАЦААНЫ ТӨЛӨВЛӨЛТИЙН БАРИМТ БИЧГИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН 2024 ОНЫ ХЭРЭГЖИЛТ

2024 оны 12 дугаар сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

| Д/д | № | Бодлогын зорилго, арга хэмжээ | Төсөв /сая төг/ | | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | | Зорилтот түвшин | | | Хэрэгжилт | Хүрсэн буюу гүйцэтгэлийн хувь | Тайлбар ( Хүрээгүй бол шалтгаан нөхцөлийн тайлбар) |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төсөвлөсөн | Гүйцэтгэл | | Он | Түвшин | Он | Түвшин | 2024 | | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | | 9 | 10 | 11 | 12 | 13 |
| ЗУРГАА. НОГООН ХӨГЖИЛ | | | | | | | | | | | | | |
| Зорилго 6. Байгалийн нөөцийг хамгаалж, экологийн тэнцвэрт байдлыг хангах замаар хүрээлэн буй орчны доройтлыг бууруулж, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицно. | | | | | | | | | | | | | |
| Зорилт 6.1. Байгалийн нөөцийг хадгалж, хамгаалан, нөхөн сэргээнэ. | | | | | | | | | | | | | |
| Зорилт 6.2. Орчны бохирдлыг багасгаж, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулна. | | | | | | | | | | | | | |
| 185 | 6.2.1 | Нийслэлийн гэр хорооллын айл өрхийг сайжруулсан түлшээр бүрэн хангаж, агаарын бохирдл | 102,911.0 | 71.027,0 | Сайжруулсан түлшээр хангагдсан хороо | 2019 | 99 | 2021-2025 он | 114 | 108 | **Сайжруулсан шахмал түлшний тээвэрлэлт:** Нийслэлийн Засаг даргын 2024 оны “Эрх шилжүүлэх тухай” А/118 дугаар захирамжаар нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд сайжруулсан шахмал түлш тээвэрлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахыг | 90% | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ыг бууруулсан байна. | | | | | | | | | Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, гэрээ байгуулан ажилласан. Энэ ажлын хүрээнд нийслэлийн 7 дүүргийн хэмжээнд 2024-2025 онд сайжруулсан шахмал түлш тээвэрлэх 30 багц ажлыг www.tender.gov.mn-д зарлаж 29 тээврийн компанийг хуулийн хүрээнд сонгон шалгаруулж "Сайжруулсан шахмал түлш тээвэрлэх гэрээ"-г байгуулсан. 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрөөс 2025 оны 12 дүгээр сарын 13-ны өдрийн байдлаар 29 тээврийн компани нь зүүн болон төвийн бүсийн үйлдвэрээс эцсийн борлуулалтын цэг, агуулахад нийт 605,493 тонн сайжруулсан шахмал түлшийг тасралтгүй тээвэрлэн ажиллаж байна. Сайжруулсан шахмал түлш тээвэрлэгч аж ахуйн нэгж байгууллагуудад тээвэрлэсэн түлшний тонн хэмжээ болон гүйцэтгэлийг хянан 2024 | 90% | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | оны 12 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар 21,69.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгон ажилласан.<br>**Сайжруулсан шахмал түлшний борлуулалт:**<br>Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд 2024-2025 онд сайжруулсан шахмал түлш борлуулагч 670 борлуулалтын цэгийг нээн ажиллуулахаар төлөвлөснөөс 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар 582 цэг ажиллуулаад байна. Гэр хорооллын 203,683 айл өрхөд сайжруулсан шахмал түлшийг ханган нийлүүлж, борлуулалтын цэгийн өдөр тутмын түлшний татан авалт, борлуулалтад хяналт тавин ажиллаж байна. Борлуулалтын урамшуулалд нийт 6,0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгоод байна.<br>**Сайжруулсан шахмал түлшний нөөцлөлт:**<br>Нийслэлийн Засаг даргын 2024 оны “Эрх шилжүүлэх тухай” А/121 дугээр | 90% | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | захирамжаар 2024-2025 оны халаалтын улиралд гэр хорооллын айл өрхийн хэрэгцээнд зориулж 100 мянган тонн сайжруулсан шахмал түлшний нөөц бүрдүүлж ажиллахыг НАОБТГ-т үүрэг болгосон. Энэхүү үүргийн хүрээнд НАОБТГ-ын даргын тушаалаар агуулах түрээслэх, сонгон шалгаруулах ажлын хэсгийг байгуулан 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн зохион байгуулж, шаардлага хангаж түлш нөөцлөх боломжтой 40 агуулахыг сонгон шалгаруулсан. 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар сайжруулсан шахмал түлш нөөцлөх боломжтой шаардлага хангасан 40 иргэн, аж ахуйн нэгж байгууллагатай “Сайжруулсан шахмал түлш нөөцлөх, гурвалсан гэрээ”-г байгуулан “Таван толгой түлш” ХХК, сайжруулсан шахмал түлшний тээврийн компаниудтай хамтран 73,678 тонн сайжруулсан шахмал түлшний нөөц | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | бүрдүүлэн ажиллаж байна. 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар 5,523 тэрбум төгрөгийн санхүүжилт олгоод байна. | | |
| 186 | | | | 130.000 | PM 2.5 тоосонцрын дундаж агууламж | 2018 | 64 | | 40 | 48 | **2023-2024** оны хүйтний улирал буюу 2023 оны 10-12 сар, 2024 оны 1-4 дүгээр сарын Улаанбаатар хотын агаар дахь бохирдуулах бодисын дундаж агууламжийг өмнөх оны мөн үеийн дундаж агууламжтай харьцуулахад PM2.5 тоосонцор 62 мкг/м3 буюу 2%-иар их байна. | 100% | |
| 187 | | | | | PM10 тоосонцрын дундаж агууламж | 2018 | 141 | | 88 | 100 | **2023-2024** оны хүйтний улирал буюу 2023 оны 10-12 сар, 2024 оны 1-4 дүгээр сарын Улаанбаатар хотын агаар дахь бохирдуулах бодисын дундаж агууламжийг өмнөх оны мөн үеийн дундаж агууламжтай харьцуулахад PM10 тоосонцор 99 мкг/м3 буюу 7%-иар бага байна. | 100% | |
| 188 | 6.2.2 | Агаарын чанарын хяналтыг | 5.0 | | Агаар бохирдуулагч эх үүсвэрүүд | 2020 | 0 | 2021-2025 | 1 | 1 | Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын дэргэдэх Агаарын чанар хяналтын | 70% | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | сайжруулсан байна. | | | ийг судалж, шинжлэх иж бүрэн лаборатори | | | | | | лабораторийг Олон улсын MNS ISO/IEC 17025:2018 стандартад нэвтрүүлэх ажлын хүрээнд 2022 онд олон улсын MNS ISO/IEC 17025:2018 стандартын шаардлагыг хангасан лаборатори гэж итгэмжлэгдэж TL 176 дугаартай Итгэмжлэлийн гэрчилгээ авсан.<br>2024 онд итгэмжлэлийн гэрчилгээг сунгуулахаар хүсэлтээ өгч ажиллаж байна.<br>**2020-2024** онуудад агаар бохирдуулагч эх үүсвэрүүд, хатуу түлшний хэмжилт хийх иж бүрэн лабораторийн барилга барих хөрөнгийг шийдүүлэхээр жил бүрийн төсөвт тусган санал хүргүүлсэн боловч 2024 оны төсөвт суугдаагүй тул тус ажил хойшлогдсон.<br>**2025** оны төсвийн саналд 1,5 тэрбум төгрөгийн санхүүжилт хүсэхээр санал хүргүүлэн ажилласан. | | |
| 189 | | | 1,000.0 | | Нийслэлийн агаарын бохирдлыг хянах | 2019 | 6 | | 9 | 8 | Орчны агаарын чанарын хяналт шинжилгээний явуулын станц-1ш" худалдан авах тендер шалгаруулалтыг зарлан | 80% | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | суурин станц | | | | | | "ЭМ АЙ ЭС ЭС" ХХК-тай 894,497,498 төгрөгөөр гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэсэн үнэлгээний хорооны зөвлөмж гарч Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яаман дээр гэрээ хийгдэж байна. | | |
| 190 | | | 150.0 | 389.928 | Агаар, орчны бохирдлыг бууруулахад олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, зөв дадал хэвшилд сургахад чиглэсэн мэдээлэл сурталчилгаа, нөлөөллийн аян зохион байгуулах | | 2 | | 10 | 8 | Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд "Ногоон технологи-2024" үзэсгэлэнг 9 дүгээр сарын 18,19-ний өдрүүдэд Сүхбаатарын талбайд зохион байгуулсан. Тус өдөрлөгөөр байгальд ээлтэй, нөөцийн хэмнэлттэй, дэвшилтэт техник, технологи инновацын шийдлээ танилцуулж, нийт 80 аж ахуй нэгж байгууллагууд оролцож 2 өдрийн турш нийт 5000 гаруй иргэд олон нийтэд сурталчилж ажилласан болно. Уг ажлын хүрээнд 5 мэдээллийн сувгаар видео болон ярилцлага үйл явдлын мэдээ, сурвалжлаг зэрэг мэдээллийг нийт 10,000 гаруй иргэд олон нийтэд хүргэж ажилласан. Мөн угаарын хийн | 100% | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | хордлогоос урьдчилан сэргийлье, зуухаа зөв галлах зааварчилгаа, байшин сууц хаагуураа дулаанаа алддаг талаар, хямд аргаар хэрхэн гэрээ дулаалах зэрэг мэдээлэл багтаасан нийт 1200 гаруй брошюрыг иргэд олон нийтэд танилцуулж тараан хүргэсэн. Мөн хагас жилийн байдлаар 9 дүүргийн хэмжээнд 3 төсөл хөтөлбөр хэрэгжүүлж, гэр дулаалах заавар зөвлөмж бүхий видео болон пасторыг цахим хуудсаар дамжуулан 2.0 сая хүнд хүрч 40.000 хүн хариу үйлдэл үзүүлж, 14,300 хүн бусадтай хуваалцаж, 700 гаруй хүн сэтгэгдэл үлдээж иргэд олон нийтэд сурталчилж ажилласан болно.<br>Нийслэлийн Засаг даргын А/1025 захирамжийн хүрээнд үүрэн телефоны үндэсний оператор Юнител ХХК-ний ДДЭШ кабелийн телевизээр 3 удаагийн давтамжаар нийт зорилтод бүлгийн 15000 өрхөд Угаарын хийнээс урьдчилан | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | сэргийлэх, зөв галлагаа, угаарын хийн мэдрэгчийг зөв ашиглах талаар зөвлөмж хүргүүлэн ажилласан болно. | | |
| | | | | | | | | | | | Дундаж хувь | 90% | |

ТАНИЛЦСАН:
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.МӨНХБААТАР

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА Г.АРИУНТУНГАЛАГ

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
ТӨВӨЛЛӨГӨӨ, ТОГТООЛ
ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Р.ЖАМБАЛСҮРЭН